



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 0158

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх, түрээслэгчийг сонгон шалгаруулах журам”-ын 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн “Өргөө” амаржих газрын эмнэлгийн хоол үйлдвэрлэлийн зориулалттай талбайн түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга

М.Мандах

Нийслэлийн Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн дарга

Гишүүд

Д.Ганбаяр

Нийслэлийн Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн

Ц.Цолмон

Нийслэлийн Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн

Т.Энхбаатар

“Өргөө” амаржих газрын тархвар судлаач

Нарийн бичгийн дарга

Ж.Сувданзаяа

Нийслэлийн Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

2. Сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэг /М.Мандах/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ